

СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2024.12.09

Баруун-Урт

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорил тот түвши н	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
1.1	Засгын газрын 2022 оны ЗГ- 2/593 үүрэг	Хүчтэй газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийн хэмжээг бичигч багажийг суурилуулах.	ГЭБС 30 сая төгрөг	Суурлуулсан сумдын тоогоор	-	3	Аймгийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч төмөр буюу мөсөн зудын хэмжээнд хүрч нийт малын 47.1 хувь нь хорогдож, аймгийн Онцгой Комиссоос зудын гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах сан болон Засаг даргын нөөц сан зарцуулагдаж дууссан. Үүнтэй холбогдуулан МУШС-тай байгуулсан гэрээ, ГЭБОНЗ-ын төлөвлөгөөнд тусгагдсан газар хөдлөлтийн чичирхийллийн хэмжээг бичигч багаж худалдан авах зардлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргад 32/369 тоот албан бичиг хүргүүлээд байна.
1.2	Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол	Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд гамшиг, осол болзошгүй эрсдэлээс сэргийлэх зарлан мэдээллийг сайжруулах зорилготой СЕРЕНЬ дохионы төхөөрөмж суурилуулах	ГЭБС 36,599, 800 төгрөг	СЕРЕНЬ дохионы төхөөрөмж суурилуулса н эсэх	-	3	Аймгийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч аймгийн Онцгой Комиссоос зудын гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах сан болон Засаг даргын нөөц сан зарцуулагдаж дууссан. Үүнтэй холбогдуулан Монгол улсын Шадар сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан гамшгийн үеийн эрт зарлан мэдээлэх 3 ширхэг СЕРЕНЬ дохио худалдан авах зардлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргад ОБГ-ын даргын 2024 оны 32/369 тоот албан бичиг хүргүүлээд байна.

1.3	МУ-ын Шадар сайдын нэрэмжит гамшгаас хамгаалах команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах	Сүхбаатар аймагт 2024 оны 10 дугаар сард команд штабын сургууль зохион байгуулна.	Орон нутгийн төсвөөс 90сая	Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулсан эсэх	-	1	Монгол Улсын Шадар сайдын баталсан хуваарь, төлөвлөгөөний дагуу 2024 оны 10 дугаар сард Гамшгаас хамгаалах Команд Штабын сургуулийг зохион байгуулахад санхүүгийн бэрхшээл болон орон нутгийн ээлжит сонгуулийн ажил 10 дугаар сард давхардаж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын зүгээс уг сургуулийг хийх боломжгүй шийдвэр гарсан. Уг нөхцөл байдлын харгалзан Онцгой байдлын ерөнхий газарт албан бичгээр хүсэлт хүргүүлсний дагуу 2025 оны 3 дугаар сард зохион байгуулахаар хойшлуулсан болно.
1.4	ОББ 2024 оны зорилт-2	Эрдэнэцагаан сум дахь гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангид гамшиг осолтой тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд туулах чадвар сайтай “Ланд-78” маркийн автомашинтай болох.	Улсын төсвөөс	Шуурхай албаны суудлын автомашинт ай болсон эсэх	-	1	Монгол Улсын Шадар Сайдын шийдвэр 2023 оны 12сарын 06 өдрийн 436 дугаар тогтоолоор Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 47 дугаар ангид “Япон улсад үйлдвэрлэсэн Land-78” маркийн шуурхай албаны автомашин 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдөр олгосон.
1.5	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалт	Гамшгийн эрсдэлийн санд урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний зохион байгуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг тусгах.	Улсын төсвөөс	Гамшгийн эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаан Д зарцуулсан зардлын хувиар	710,0 сая	700,0 сая	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтын дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2024 оны ээлжит хуралдааны шийдвэр 2024 оны 03 дугаар тогтоолоор аймгийн Гамшгаас хамгаалах эрсдэлийн санд 900.0 сая төгрөг, төсвийн тодотголоор нэмж 200.0 сая, нийт 1.1 тэрбум төгрөгийг батлуулж, аймгийн хэмжээнд үүссэн гамшгийн нөхцөл байдал, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зарцуулсан. 2023 онд гамшгийн эрсдэлийн санд 700.0 сая төгрөг төсөвлөж, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулсан. 2024 онд эрсдэлийн сан 400.0 сая буюу 37%-аар өмнөх оныхоос өссөн үзүүлэлттэй байна.

1.6	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлиг, МУЗГ-ын 350 тогтоол	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний аяны хүрээнд Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын мод үржүүлгийн талбайгаас 200 ширхэг улиас ,400 ширхэг гүйлс,850 ширхэг хайлаас мод шилжүүлж тарих, 1500 модны тарьц суулгац шинээр бэлдэх.	Дотоод нөөц боломж	Модны суулгац, ургалтын хувиар	1500	1500	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, 2021 оны 58 дугаар зарлигаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Онцгой байдлын газрын хэмжээнд хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрөөр хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргаж батлуулж мод тарих ажлыг газрын хэмжээнд зохион байгуулж ажиллалаа. Онцгой байдлын газрын алба хаагчид Түмэнцогт сум дахь үрслэгээний талбайгаас гүйлс-370 ширхэг, хайлаас-100ш, улиас- 260 ширхэг, чацарганын суулгац-120 ширхгийг шилжүүлэн нөхөн сэргээлт хийж байгууллагын эзэмшлийн талбайд алба хаагчдын гэр бүл, ахмад ажилчдын хамт нийт-970 ширхэг модыг /3,880,000 сая төгрөгөөр / тарих ажлыг зохион байгуулан усалгаа, арчилгааг хийж гүйцэтгэлээ.Мөн байгууллагын алба хаагчдын хувийн эзэмшлийн хашаанд мод тарих боломжоор хангаж байгууллагын үрслэгээний талбайгаас 120 ширхэг гүйлс модны үрсэлгээг анги,салбар нэгжийн алба хаагчдад тарааж гэр, бүлийн хүрээнд мод ажлыг зохион байгуулсан. Түмэнцогт сум дахь мод үржүүлгийн талбайд 0,5 гр хайлаас үр суулгаж 300 гаруй ширхэг хайлаас мод тарьц бэлдэж, 3кг гүйлсний үр суулгаж 1500 гаруй ширхэг гүйлсний тарьц бэлдэж ургалт одоогийн байдлаар 50%-тай байна.
1.7	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17.3 ГАБТ хууль 11.2	Орон нутагт үүссэн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймрийн голомтод шуурхай арга хэмжээ зохион байгуулах.	Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс	гүйцэтгэлийн хувиар	100%	-	2024 оны жилийн байдлаар аймгийн хэмжээнд гамшиг, осол, гал түймэр болон бусад төрлийн нийт 178 удаагийн мэдээ, мэдээллийг хүлээн авч гамшгийн голомтод шуурхай арга хэмжээ авч мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан байна. Үүнд 213 техник хэрэгсэл /давхардсан тоогоор/ 789 алба хаагч /давхардсан тоогоор/ гамшгийн голомтод шуурхай арга хэмжээ авч ажиллаж 550хүний амь нас 1,9 тэрбумын ард иргэдийн эд хөрөнгийг авран хамгаалж 79,6 сая төгрөг зарцуулсан байна.
1.8	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.1	Аймгийн Онцгой комиссын гишүүд болон сумдын онцгой комиссын дарга нарыг сургалтад хамруулах	Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас	Сургалт зохион байгуулсан тоо	1	2	ЗГ-ын 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн аюулын тухай” зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг 2024 оны 03 дугаар сарын 28-ны 16:00 цагт бүх шатны Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар 12 гамшгаас хамгаалах алба, 20 мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд зарлан мэдээлэх журам, газар хөдлөлтийн гамшгийг таниулах сургалт, мэдээлэл өгч, иргэдийг татан

							оролцуулж, 4492 хүнийг хамруулж ажилласан.
1.9	Ахмад настны тухай хууль	Ахмадын зөвлөлийн үйл ажиллагаа, холбогдох хууль дүрмийн хэрэгжилтийг хангах	Урсгал үйл ажиллагааны зардал	Биелэлтийн хувиар	85%	90%	Онцгой байдлын байгууллагын ахмад настны хөгжил, хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг 91.6% биелүүлж ажилласан. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/123 тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын хэрэгжилтийн хүрээнд газрын “Ахмадын зөвлөл”-д 3,060,000 санхүүжилтийг эмчилгээ, сувилалын үйчилгээ, нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, түлээ нүүрсний хөнгөлөлт, ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд 59 ахмад ажилтанг хамруулж ажилласан.
2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ							
2.1	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.1	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын дагуу Сумд болон аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, зөвлөмжийн дагуу эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах	Орон нутгийн төсөв	Эрсдэлийн үнэлгээ хийсэн тоо	10	16	Аймгийн Засаг даргын 2024 оны А/108 дугаар захирамжаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, Зудын эрсдэлийн салбар дундын үнэлгээг 4 удаа, Шар усны үерийн салбар дундын үнэлгээг 1 удаа, Хээрийн түймрийн эрсдэлийн үнэлгээг 2 удаа, Үерийн эрсдэлийн үнэлгээг 2 удаа, гангийн эрсдэлийн үнэлгээг 1 удаа, нийт 10 удаагийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж зөвлөмж боловсруулж, Улсын Онцгой Комиссын Шуурхай штаб, ОБЕГ-т хүргүүлж ажилласан. Эрсдэлийн үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг аймгийн Онцгой Комисс, Шуурхай штабт танилцуулж, авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг төлөвлөх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум дахь хилийн Бичигт боомт, Номин худалдааны төв, 3-р цэцэрлэгт аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоотой хийж, эрсдэлийн түвшинг үнэлж ажилласан. 22 аж ахуйн нэгж байгууллагын 870 ажилтан, албан хаагч, 250 сурагч, нийт 1120 хүнд гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, эрсдэлийн үнэлгээ хийх заавар, дүрэм, журмын талаар сургалт зохион байгуулсан
2.2	ГХТХ 10.4.1	Аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянах.	-	Хянах, тодотгол хийсэн тоо	40	40	Онцгой байдлын байгууллагын 2024 оны зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын нийт 36 гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж, тодотгол хийн гамшгаас хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажлын бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажилласан. Мөн шинээр үйл

							ажиллагаа эрхлэн явуулж байгаа 6 байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянан, баталгаажуулан ажилласан.
2.3	ОБЕГ-ын Тэргүүн дэд даргын 2023 оны үүрэг	Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх.	Улсын болон орон нутгийн төсөв	Биелэлтийн хувь	75%	100%	Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, хөдөлмөрийн, эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж 2 дугаар шатны аудитын батламж 2022 оны 07 дугаар сарын 05-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл сунгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2.4	МУЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоол,	Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, галын аюулгүй байдлын дүгнэлт олгох	-	Ажлын байрны дүгнэлт гаргасан тоо	162	-	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах 174 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч барилга байгууламжийн галын аюулгүй байдалд “Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм журам түүнтэй нийцүүлэн гаргасан норм, стандартын хэрэгжилт галын аюулаас хамгаалагдсан байдалд хяналт шалгалт хийж МУ-ын Шадар сайдын 2023 оны 75 дугаар тушаалын дагуу Ажлын байрны галын аюулгүй байдлын 166 дүгнэлтийг олгож, илэрсэн зөрчил дутагдалд зөрчлийг шийдвэрлэн тэмдэглэл хөтлөж ажиллаж байна.
2,5	Монгол улсын шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хэрэгжилтийг хангах	Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион	-	Хяналт, шалгалт зохион байгуулсан тоо	218	240	Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Орон сууцны зоорийн болон 1-р давхарт шингэрүүлсэн шатдаг хий ашиглан үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид, “Сендвич хавтан, тавилга, вакум цонх, бетон зуурмагийн үйлдвэр”, “Шатахуун түгээх станц /ШТС/, Автомашин хийгээр цэнэглэх станц /АХЦС/, Хий цэнэглэх станц /ХЦС/”-ын, Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, “Зочид буудал, дэн буудлын барилга байгууламж, Амралтын газар, жуулчны бааз, хүүхдийн зуслангын барилга байгууламж, “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Шатахуун түгээх станц, АХЦС, Уул

		байгуулах					уурхайн баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, Боловсролын байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж"-ийн дагуу Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад М.Дамба, ахлах дэслэгч А.Галсандорж, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч ахмад С.Батхуяг нар Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Дарьганга суманд үйл ажиллагаа явуулж буй орон сууцны зоорийн болон 1-р давхарт шингэрүүлсэн шатдаг хий ашигладаг аж ахуйн нэгж, "Сендвич хавтан, тавилга, вакум цонх, бетон зуурмагийн үйлдвэр", "Шатахуун түгээх станц /ШТС/, Автомашин хийгээр цэнэглэх станц /АХЦС/, Хий цэнэглэх станц /ХЦС/", Эрүүл мэндийн байгууллага, "Зочид буудал, дэн буудал, "Амралтын газар, жуулчны бааз, хүүхдийн зуслангын барилга байгууламж Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Шатахуун түгээх станц, АХЦС, Уул уурхайн баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, Боловсролын байгууллагын барилга байгууламжид төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион явуулж, хяналт шалгалтаар 120 барилга байгууламжийг хамруулан нийт 852 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 261 зөрчлийг арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 99 мэдэгдэл 21 тус тус бичиж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан. Нийт хяналт шалгалтанд хамрагдвал зохих объектын 55 хувийг хамруулсан бөгөөд Онцгой байдлын газрын ГТУХБ 2024 оны 08 дугаар сараас ОХУ-ын Гал эсэргүүцэх акедемид суралцахаар явж дараагийн ГТУХБ тус оны 11 дүгээр сарын 15-ны өдөр томилогдсон. Үүний улмаас сумдын иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж шалгалтанд хамрагдаагүй. Эдгээрийг 2025 онд удирдамж боловсруулан хамруулахаар ажиллаж байна.
2.6	МУШС, АЗД-ын баталсан удирдамжит нэгдсэн арга хэмжээ	Гамшиг, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Орон нутгийн төсвөөс 10 сая	Арга хэмжээ зохион байгуулсан тоо	6	6	Монгол Улсын шадар сайд, ОБЕГ-ын даргын баталсан "Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал", "Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлье", Газар хөдлөлтийн аюулаас урьдчидан сэргийлье", "Үер усны ослоос урьдчилан сэргийлье", Гамшгийн эрсдэлийн бууруулах Олон улсын өдөр" нэгдсэн арга хэмжээний удирдамж, Улсын Онцгой комиссын 01, 02 тоот албан

						даалгарын хүрээнд хүрээнд аймгийн болон 13 сумын Засаг даргын Тамгын газар, “Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар, “ДБЭХС,ТӨХК-ийн Сүхбаатар салбар, Улаан загалмайн хороо, Японы хүүхдийг ивээх сантай хамтран олон нийтийг гал түймэр, гамшгийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажилласан. Тус нэгдсэн арга хэмжээний хүрээнд Засаг даргын 2024 оны А/108 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдон аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үүсэх Шар усны үерийн эрсдэлийн салбар дундын үнэлгээ хийж шар усны үерт өртөж болзошгүй 1065 өрхийн судалгааг гаргасан. Онцгой байдлын байгууллагаас шар усны үерт өртөж болзошгүй 37 өрхийг нүүлгэн, сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангитай хамтран 183 өрхийг цаснаас гарган ажилласан. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх “Зарлан мэдээлэл”-ийн дуут дохио дамжуулах нэгдсэн дадлага сургуульд 4492 иргэн хамрагдсан. Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт байрлах Баруун голын эрэг дагуу шалгалт хийн усны гүн, цүнхээлийг тогтоон эрсдэл өндөр 5 цэгт, 1.500.000 төгрөгөөр усны ослоос урьдчилан сэргийлэх, анхааруулах самбаруудыг шинээр байрлуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны А/513 захирамжаар гамшгийн эрсдэлийн сангаас 9,781,140 төгрөгийг батлуулсан. Тус ажлын хүрээнд Онцгой байдлын газрын даргын тушаалаар Эрэн хайх, аврах салбарын 12 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй бүлэг томилогдон хээрийн түймэр гарах эрсдэл өндөр Дарьганга сумын Шилийн богд орчмын бүс нутагт 28 хоног эргүүл хяналтын байнгын бүлэг байрлан үүрэг гүйцэтгэсэн. Хээрийн түймрийн эрсдэл өндөртэй Сүхбаатар, Эрдэнэцагаан, Дарьганга, Асгат сумдад "ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦОО ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ" уриан дор хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажилласан. Мөн Онцгой байдлын газраас 4 сумын Засаг даргын Тамгын газарт хээрийн түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах зорилгоор тус бүр 2 ширхэг /нийт 8 ширхэг/ үлдээгч аппаратыг хүлээлгэн өгсөн. Дарьганга сумын Шилийн богд орчим хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, аялал зугаалгаар зорчиж байгаа иргэд, автомшины техник хэрэгслийн хөдөлгөөнийг хянах 4G
--	--	--	--	--	--	---

							20X ZOOM Solar Ubox загварын 360 градус эргэдэг хяналтийн камерыг суурьлуулсан. Старлинк номад /Starlink Nomad/ төхөөрөмжийн сүлжээний хэвийн ажиллагааг ханган 3 сараар эрхийг сунган ой, хээрийн гал түймэр болон гамшиг ослын үед ашиглан холбоо мэдээллийг түргэн шуурхай солилцох, дамжуулахад төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан.
2.7	МУЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоол	Барилгын зураг төслийг хянах, Улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах,	-	Барилгын зураг төслийг хянасан тоо	30	-	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/47 тоот тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, ашиглалтанд оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах журам”-ын дагуу нийт 31 иргэн, хуулийн этгээдийн зураг төслийг зөвшилцөн 1,550,000 мянган төгрөгийг аймгийн татварын хэлтсийн дансанд төвлөрүүлж ажилласан. Үүнээс барилга байгууламжийн 10 ажлын зураг, шугам сүлжээ, дэд бүтэц, гадна цахилгааны 12 ажлын зураг, гудамж талбайн тохижолтын 6 ажлын зураг, барилга байгууламжийн засварын 3 ажлын зурагт галын аюулгүй байдлын магадлал хийсэн дүгнэлт гаргаж ажилласан. Мөн тус журмын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст 15 удаа ажиллахдаа, үүрэг даалгаврын биелэлтийг 15-н иргэн хуулийн этгээдэд өгч, хангуулсан материалыг 13-н иргэн хуулийн этгээдээс гаргуулж байнгын ашиглалтанд хүлээн авч ажилласан.
2.8	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол	Аймгийн даргын газрын шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд мэдээллийн хэрэгжилтийг хангуулах. Засаг тамгын хяналт-цахим орсон	Хөрөнгө шаардл агагүй	Биелэлтийн хувиар	91,1%	95%	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулж байгаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын захирамж, ИТХ-ын тогтоолын хэрэгжилт, сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, гүйцэтгэлийн төлөвлөгөө, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлтийг сар, улирал, хагас бүтэн жилээр гаргаж баталгаажуулж ажилласан. Аймгийн Засаг даргатай байгуулсан 4 зорилтын 43 заалт бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны эхний хагас жилээр биелэлтийг 85.7% В үнэлгээтэй дүгнэгдсэн.

2.9	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйл	Монгол Улсын Шадар Сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд Онцгой байдлын газартай холбогдох ажлын хэрэгжилтийг хангах	Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс	Гэрээний биелэлтийн хувиар	88%	90%	Монгол Улсын Шадар Сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд Онцгой байдлын газраас гамшигтай тэмцэх, эрсдэлийг бууруулж, хойшлуулшгүй сэргээн босгох чиглэлийн 8 заалт бүхий ажил тусгуулж хэрэгжилтийгэхний хагас жилд 64.3%, жилийн эцсээр 85.7%-тай хангаж ажилласан. 2023-2024 оны өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотой гамшгаас хамгаалах сан, Засаг даргын нөөц хөрөнгийг гамшигтай тэмцэх, сэргээн босгох үйл ажиллагаанд зарцуулж дууссантай холбоотой гэрээнд тусгагдсан 2 ажил, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.
-----	--	--	--	----------------------------	-----	-----	--

3. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

3.1	“Галын аюулгүй байдлын тухай хуулийн” 7.1, 7.2, 15.1.3 заалт.	Баруун-Урт, Эрдэнэцагаан сумдад “Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/135 тоот” “Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу зохион байгуулах.	Улсын төсвөөс	Сургалт зохион байгуулсан тоо	88	92	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн А/135 дугаар тушаал “гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөө боловсруулах заавар”-н дагуу Гал түймэр унтраах, аврах 15 анги нь Баруун-Урт сумын 48 аж ахуй нэгж байгууллагад, Гал түймэр унтраах, аврах 47 дугаар анги нь Эрдэнэцагаан сумын 36 аж ахуй нэгж байгууллагад /Эрдэнэцагаан суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын тоотой холбогдуулан боловсруулав/ гал түймэр унтраах тархалтын дадлага сургалтын төлөвлөгөөний хуваарь гаргаж газрын даргаар батлуулан хуваарийн дагуу Баруун-Урт, Эрдэнэцагаан сумын аж ахуй нэгж байгууллагад Тархалтын дадлага сургалтыг 84 удаа, Тактикийн дадлага сургалтыг 8 удаа тус тус зохион байгуулсан.
-----	---	--	---------------	-------------------------------	----	----	---

3.2	ОБЕГ-ын А/323 тушаал	2017 тоот	Эрдэнэцагаан, Сүхбаатар, Асгат, Дарьганга сумдад бэлэн байдлын үзлэг, Мөнххаан, Баруун- Урт сумдад Гамшгаас хамгаалах команд штаб, Түмэнцогт суманд иж бүрэн сургууль зохион байгуулах	Орон нутги йн төсвө өс	Сургалт зохион байгуулса н тоо	7	7	Тус газраас аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Эрдэнэцагаан, Сүхбаатар, Асгат, Дарьганга сумууд бэлэн байдлын үзлэгийг 2024 оны 10 дугаар сард зохион байгуулж, сумын Онцгой Комисс, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллагын гамшигтай тэмцэх чадавхи, бэлтгэл бэлэн байдлыг хангуулсан. Мөнххаан, Түмэнцогт сумын гамшгаас хамгаалах команд штабын сургууль, дадлагыг 11 дүгээр сард зохион байгуулахаар албан бичиг удирдамжийг хүргүүлсэн боловч, Түмэнцогт сумын Засаг даргын ... тоот албан бичгээр сургуулийг хойшлуулах хүсэлт тавьсан. Мөнххаан сумын КШ-ын сургууль, дадлагыг 12 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсөн.
3.3	ЗГ-ын 339, 340 дүгээр тогтоол		Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль, Газар хөдлөлтийг таниулах өдрийг зохион байгуулах.	ГЭБС 1,000,0 00 төгрөг	Зохион байгуулсан тоо	2	2	Гамшгийн аюулын тухай” зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг зохион байгуулах ажлыг 13 сумд, гамшгаас хамгаалах орон нутгийн 12 алба, 20 мэргэжлийн анги, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийг хамруулан 837 хүнд танхимын сургалтыг зохион байгуулж ажиллана. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх “Зарлан мэдээлэл”-ийн дуут дохио дамжуулах нэгдсэн дадлага сургуульд 4492 иргэн хамрагдсан.

3.4	ОБЕГ-ын оны тушаал	2020 А/133	Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Хамрагдсан ААНБ-ын тоо	300	330	Гамшгийн эрсдэлийг бууруулахад орон нутаг ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гал түймэр, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх боловсрол олгох, өөрийгөө болон бусдын амь насыг авран хамгаалах мэдлэг, дадлагыг олон нийтэд олгох, удирдах бүрэлдэхүүн, ажилтан, иргэд, оюутан сурагчдын сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтны сургалт – 175 удаа 249 цаг 4038 хүн, Удирдах бүрэлдэхүүн сургалт-7 удаа 14 цаг 217 хүн, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги сургалт-13 удаа 25 цаг, 370 хүн, Иргэний сургалт-24 удаа 39 цаг, 2148 хүн, Сайн дурын бүлэг хэсгийн сургалт-3 удаа 8 цаг, 104 хүн, МСҮТөв, коллежийн оюутан , сурагчдын сургалт-5 удаа 8 цаг 111 хүн, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сургалт-82 удаа 72 цаг 5327 хүн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сургалт-1 удаа 1 цаг 66 хүн, Сургуульд элсэхээс өмнөх насны хүүхдийн сургалт-48 удаа 26 цаг 1614 хүн, Цэргийн дүйцүүлэх албаны сургалт-1 удаа, 3 цаг, 30 хүн Гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургууль-1удаа 48 цаг 78 хүн, Ангиллын сургалтад нийт: 360 удаа, 493 цаг, 14103 иргэн хамрагдсан байна.
-----	--------------------------	---------------	--	--------------------------	------------------------------	-----	-----	--

3.5	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоол	Сургуулийн өсвөрийн аврагч нарын дунд “Өсвөрийн аврагч-2024” аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах.	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан тоо	1	1	ОБЕГ, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын сайдын хамтарсан 2019 оны 114/А/765 дугаар тушаал, “Эрсдэлийн боловсрол” аяны хүрээнд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Улаан загалмайн хороотой хамтран “Өсвөрийн аврагч-2024” чадавхжуулах сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн Өсвөрийн аврагч бүлгэм, Өсвөрийн Улаан загалтайн идэвхтэн гишүүдийн хамруулан аюулт үзэгдэл, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэхэд сургаж дадлагажуулах зорилгоор онолын мэдлэг олгон сургалт, дадлагыг зохион байгуулсан.
3.6	“Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам”	Уснаас Эрэн хайх, аврах ажиллагааны хамтарсан дадлага сургууль зохион байгуулах.	Урсгал үйл ажиллагааны зардал	Зохион байгуулагдсан эсэх	1	1	2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 24-ний өдрүүдэд Зүүн бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 0287 дугаар анги, 0275 дугаар анги, 0306-дугаар ангиудтай хамтран Дорнод аймгийн Халхгол сумын Буйр нуурыг түшиглэн зохион байгуулсан “Усан бэлтгэлийн бүсчилсэн сургалт”-нд Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын аврагч-усчин 2 алба хаагчийг 10 хонгийн хугацаанд хамрагдаж мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн.
3.7	ОБЕГ-ын даргын 2016 оны А/157 дугаар тушаал	Гал унтраах үндсэн, туслах, шуурхай албаны автомашинуудад “Тээврийн хэрэгсэл ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангах	Урсгал үйл ажиллагааны зардал	Хэрэгжилтийн хувиар	90%	95%	Онцгой байдлын газрын хэмжээнд нийт 28-н тээврийн хэрэгсэлээс объектын гал түймрийн үндсэн албаны 4, туслах албаны тусгай зориулалтын 5, шуурхай албаны 2, эрэн хайх, ажиллагааны 4, хээрийн түймрийн зориулалтаар ашиглах -8 автомашин буюу нийт 23-н автомашинтай албаны бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 05 сарын 31 ны 208 дугаар тогтоолоор Ланд-76, шуурхай албаны автомашин, 190.000.000 Ковш дугуйт ачигч хүлээн авч акт үйлдэн автотээврийн газарт бүртгүүлж улсын дугаар гэрчилгээ авсан. Техникийн шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй 6-н автомашиныг актлуулахаар ОБЕГ-ын өмч хамгаалах зөвлөлд санал хүргүүлсэн. 2024 онд автомашин техникийн бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэхээр үндсэн болон туслах, шуурхай албаны автомашинуудад жолооч нараар ТҮ-1, 2, улирлын үйлчилгээг цаг тухайд хийлгэж, өвлийн улирлын

							үйлчилгээгээр 3,500,000, 2024 онд нийт шаардлагатай засвар үйлчилгээнд Аймгийн онцгой комисс, төсвөөс болон хандив тусламжаар 20,064,000 төгрөгний сэлбэг хэрэгсэл зарцуулаад байна. Хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан тээврийн хэрэгсэл, багаж зэвсэглэмжинд үзлэг шалгалт хийж, шаардлагатай засвар, улирлын үйлчилгээг хариуцсан жолооч нараар хийлгэж бэлтгэл бэлэн байдлаа хангаж ажилласан.
3.8	Төрийн албаны тухай хуулийн 55.3	ОБЕГ-ын даргын 2019 оны А/183 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	Урсгал үйл ажиллагааны зардал	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар	92%.	95%	Тус газраас алба хаагчдыг мэргэшүүлэх, боловсролын түвшинг ахиулах зорилгоор ДХИС-ийн Онцгой байдлын сургуульд нийт 6 алба хаагчийг суралцуулж байгаагаас Онцгой байдал-гамшгаас хамгаалах чиглэлээр бакалаврын хөтөлбөрт 3 офицерыг, 3 ахлагчийг тус тус 3-5 жилийн хугацаанд суралцуулж байна. Мөн Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн мэргэжил олгох сургалтад хүний нөөц бүрдүүлэх зорилгоор 12 алба хаагчийг сургаж байна. Ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалт 97.6%, офицер бүрэлдэхүүний хангалт 96.6 % байна. Төрийн албаны зөвлөлийн 7.4.10 цахим сургалтад болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан Онцгой байдлын байгууллагын 2024 оны бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай, Онцгой байдлын газрын даргын “2024 оны сургуулийн жилд сургалт, бэлтгэлийг зохион байгуулах тухай” А/01 дугаар тушаалаар сургалтын төлөвлөгөөг баталж, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улст, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад олон улсын чанартай зохион байгуулагдсан сургалтад 11 алба хаагч хамрагдаж мэргэжлийн ур чадвараа дээшлүүлж ажилласан байна. Онцгой байдлын ерөнхий газар болон Бүсийн төв, орон нутагт төрөл мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдсан удирдах бүрэлдэхүүний болон алба хаагчдад богино хугацааны сургалтад давхардсан тоогоор 67 алба хаагч хамрагдсан байна.

							Баруун-Урт, Сүхбаатар сумын ЕБС-ын сургуулийн 12 дугаар ангийн 120 хүүхдүүдэд мэргэжил сонгох, Онцгой байдлын албаны чиг үүргийг танилуулах сургалт зохион байгуулсан.
3.9	ОББ 2024 оны зорилт-2	Гамшиг, ослын үед агаараас тандах ажиллах, эрэн хайх аврах ажиллагаанд ашиглах дрон авах	Орон нутгийн төсвөөс 6.000.000	Төхөөрөмжийн хэрэгжилтийн хувь	-	1	Аймгийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч аймгийн Онцгой Комиссоос зудын гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах сан болон Засаг даргын нөөц сан зарцуулагдаж дууссан. Үүнтэй холбогдуулан Монгол улсын Шадар сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан гамшгийн үеийн эрт зарлан мэдээлэх 3 ширхэг СЕРЕНЬ дохио худалдан авах зардлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргад ОБГ-ын даргын 2024 оны 32/369 тоот албан бичиг хүргүүлээд байна.
3.10	ОББ 2024 оны зорилт-2	Гамшиг, ослын үед холбоо зохион байгуулах Starlink төхөөрөмж авах	Орон нутгийн төсвөөс 6.000.000	Төхөөрөмжийн хэрэгжилтийн хувь	-	1	Аймгийн засаг даргын захирамжаар СТАРЛИНК НОМАД төхөөрөмжийг 6.0 сая төгрөгөөр худалдан авч аймаг, орон нутгийн гамшгийн голомтод холбоо зохион байгуулах чадавхи, Гамшгийн орон зайн мэдээллийн системээс байр зүйн зурагтай ажиллаж гал түймэр, гамшиг ослын эрсдэлийг тооцоолох, тактик төлөвлөгөө боловсруулах, тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөн үйлдэх явцад өндөр хурдны интернэтд холбогдох боломжтой WiFi цацах өндөр хурдны интернет 200mbps 0~200км/ц түүнээс дээш хурдтай явахад хэвийн ажиллах төхөөрөмжийг авсан.
3.11	ОББ 2024 оны зорилт-3	Офицеруудын нэгдсэн цугларалт зохион байгуулах.	Улсын төсвөөс	Цугралт зохион байгуулсан тоо	1	1	2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр офицер бүрэлдэхүүний нэгдсэн цугларалт сургалтыг зохион байгуулсан. Офицер бүрэлдэхүүний сургалтаар Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, “Байгууллагын соёл”, Цагдаагийн газраас замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн дэслэгч Л.Балжинням “Зөрчлийн тухай хууль” болон “Эрүүгийн хууль”-ийн нэмэлт өөрчлөлтийн талаар, "Гэр бүлгийн бахархал" нийгэмд үйлчлэх ТББ-ын тэргүүн С.Аюурзана “Хөгжиж өөрчлөгдөх амжилтын нууц”, “Би гэж хэн бэ?”, “Дотоод ба гадаад ертөнц” сэдвээр сургалт зохион байгуулж, Онцгой байдлын газрын дарга офицер бүрэлдэхүүн болон салбар, нэгжийн дарга /захирагч/ нарт 2024 онд хэрэгжүүлэх үүргийг чиглэл тус нийт 9 үүргийг өгч ажилласан.

3.12	ОБЕГ-ын даргын 2020 оны А/308 “ОБА бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлтийг зохион байгуулах тухай тушаал	2024 оны Бие бүрэлдэхүүний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, албаны болон мэргэжлийн сургалтыг зохион байгуулж, сургагч багш нарын оролцоог нэмэгдүүлэх.	Улсын төсвөөс	Биелэлтийн хувиар	90	95	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан Онцгой байдлын байгууллагын 2024 оны бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай тушаалыг хэрэгжүүлж, Онцгой байдлын газрын даргын “2024 оны сургуулийн жилд сургалт, бэлтгэлийг зохион байгуулах тухай” А/01 дугаар тушаалаар сургалтын төлөвлөгөөг баталж, тушаалын хэрэгжилтийг хангаж, дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Сургуулийн жилийн нээлтээр офицерын манлайллыг нэмэгдүүлэх, цэрэгжилт жагсаалч байдлыг дээшлүүлэх зорилгоор алба хаагчдад жагсаалын бэлтгэл сургалт, жагсаалын үзлэгийг зохион байгуулсан. Сургуулийн жилийн эхний хагаст онолын хичээл буюу албаны бэлтгэл хичээлийг танхимаар түлхүү зохион байгуулж, заагдсан хичээлийг цахим хэлбэрт буюу Google-Classroom платформын цахим ангид давхар байршуулж, бие даан сурах нөхцөлөөр хангаж суралцах бүхий л боломжийг бүрдүүлж, танхимын болон цахим хосолсон сургалтын арга барил ашиглаж ажиллав. Зохион байгуулсан сургалтыг задалж үзвэл: - Албаны болон мэргэжлийн бэлтгэл, - танхимын сургалт/-д Офицер, бүрэлдэхүүн: 57 удаа, 114 цаг, давхардсан тоогоор 1424 алба хаагч, Ахлагч бүрэлдэхүүн: албаны бэлтгэл сургалтад 44 удаа, 5 цаг, давхардсан тоогоор 2901 алба хаагч, - Мэргэжлийн бэлтгэл: Төрөл мэргэжлийн аврагчийн сургалт – давхардсан тоогоор 363 удаа, 726 цаг, 2904 алба хаагч хамрагдсан. - Тактикийн дадлага сургалт 8 удаа, - Тархалтын дадлага сургалт 84 удаа нийт давхардсан тоогоор 1251 ажилтан, алба хаагчийг хамруулан зохион байгууллаа.
3.13	Төрийн болон	Төрийн болон	Хөрөнгө	хэрэгжилтий	90%	94%	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/231

	албаны нууцын тухай хууль	албаны нууцыг хамгаалах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууцын албан хэрэг хөтлөлтийг хэрэгжүүлэх.	шаардл агагүй	н хувиар			дүгээр тушаалаар батлагдсан Төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах журмын хүрээнд нууцын ажлыг бүрэн хөтлөн, ажиллаж байна. Нууцын хадгалалт хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024.01.15-ны өдөр аймгийн Тагнуулын хэлтэст хүргүүлсэн. ОБЕГ-ын даргын 2023 оны А/122 дугаар “Журам батлах тухай” тушаал, ОБЕГ-ын даргын 2024.06.07-ны өдрийн 1/1353 тоот үүргийн хэрэгжилтийн хүрээнд Онцгой байдлын газрын нууцтай танилцах эрх бүхий нийт 15 албан тушаалтнуудаас нууцын баталгаа гаргуулж ажилласан Байгууллагын нууц хариуцсан ажилтаны өрөөг зориулалтын төмөр хаалга, биет хамгаалалтын хүндрүүлэгчтэй цефт, цонхны хамгаалалтын тор зэргийг шинээр хийж биет хамгаалалтыг сайжруулж ажилласан.
3.14	Авлигын эрсэг тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.8 заалт	Хувийн ашиг сонирхлын хөр өнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг холбогдох албан тушаалтнаар үнэн зөв гаргуулж, баталгаажуулах.	Хөрөнгө шаардл агагүй	Хамрагдсан алба хаагчдын тоогоор	18	16	2023 оны Хөрөнгө орлогоо мэдүүлэх алба тушаалтнууд болон шинээр томилогдсон ТТ-7-оос доош шатлал зэрэглэлээр цалинждаг 16 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулж, мэдүүлэг баталгааны маягыг баталгаажуулж, ХАСХОМ-1, 2 тайланг ОБЕГ-ын хуулийн тасагт 2024 оны 02 сарын 16-ны өдөр хүргүүлж ажиллав. Нийт хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг алба хаагч нарт сургалтыг зохион байгуулж хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлгийг гаргуулсан. АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан шинээр томилогдсон ЭБАТ нарт зориулсан цахим сургалтад хамрагдсан.
4. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
4.1	Аймгийн Засаг даргын 2022 оны А/206 тоот захирамж	Аймгийн Онцгой Комисс, Шуурхай штабын оператив бүлгийн үйл ажиллагааг шууд удирдлагаар ханган зохион байгуулах.	Орон нутгийн төсөв	Хурлаас шийдвэрлэсэн асуудлын тоо	37	-	2023-2024 оны өвөлжилтийн нөхцөл байдал, зудын гамшиг, үер усны осол зэрэг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар зуд, үерийн гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Шуурхай штабыг байгуулж ажилласан ба сум бүрт шуурхай штаб байгуулж, 24 цагаар жижүүр томилон ажиллуулсан. Үүсэн нөхцөл байдалтай уялдуулан аймгийн Онцгой Комиссыг 11 удаа хуралдуулан 50 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 21 албан тоот, аймгийн Засаг даргын албан даалгавар 6, аймгийн Онцгой комиссын албан даалгавар 3,

							аймгийн Засаг даргын захирамж 35-ыг гарган аймгийн Засаг даргын 2024 оны А/04, А/198 тоот захирамжуудаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 2024 оны 05 сарын 15-ныг хүртэл шилжүүлж ажилласан.
4.2	Шилэн дансны тухай хууль	Санхүүгийн мэдээллийг байгууллагын ил тод байдлын самбарт байршуулж, олон нийтэд хүргэж ажиллах	-	Байршуулсан тоо	98%	100%	Төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ, бараа материалын худалдан авалт, Онцгой байдлын ерөнхий газраас хүлээн авсан багаж зэвсэглэмж, тоног төхөөрөмж, хувцас хангалтын тайланг сар бүр байгууллагын мэдээллийн самбар болон https://shilendans.gov.mn/ шилэн дансанд нэгтгэж байршуулсан.
4.3	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль	Онцгой байдлын газрын батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, өр авлагын мэдээг сар бүр гаргаж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж, баталгаажуулж, ОБЕ Г-т хүргүүлэх	Урсгал үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэлийн хувиар	12	12	2024 оны төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулж, сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулан баталгаажуулан ОБЕГ-ын САТГ-т хүргүүлж, өр авлага үүсгэлгүй ажилласан.
4.4	Гамшгаас хамгаалах тухай хууль, МУ-ын Засгийн газрын тогтоол “журам батлах тухай”	Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын томилолт, урамшууллыг шийдвэрлүүлэх	Дээд шатны байгууллагын санхүүж илт	Шийдвэрлэсэн эсэх	4	4	Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газраас 1,2,3 дугаар улирлын гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын томилолтын анхан шатны баримтыг хүргүүлэн 47,9 сая төгрөгийн зардал шийдвэрлүүлж, албан хаагчдад олгосон.
4.5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйл, ЭМС-ын 2014 оны 340 дугаар	Алба хаагчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношлогоонд хамруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	Дотоод нөөц боломж	Алба хаагчдын өвчлөлийг эрт илрүүлж, эрүүлжүүлсэн хувиар	34.7%	50%	Онцгой байдлын газар, ГТУА 15 дугаар анги, ЭХАС-ын томилгоот харуул ээлж болон эрүүл мэндийн тусламж шаардлагатай 470 алба хаагч, Эрдэнэцагаан сум дахь ГТУА-47 дугаар ангийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүнийг дуудлага хүлээн авагч нар өдөр бүр хяналт тавьж 780 алба хаагч, Түмэнцогт сум дахь ЭХА бүлгийн алба хаагчдыг аврагч, ахлагч С.Наран-Эрдэнэ хяналтын үзлэг тогтмол

	тушаалын хавсралт, 1-р	арга хэмжээ зохион байгуулах,					хийж 870 алба хаагч, нийт газрын хэмжээнд 2110 алба хаагчдад урьдчилан сэргийлэх, артерийн даралт, пульс хэмжих хяналтын үзлэгт хамруулсан. Үүнээс эрүүл мэндийн анхан шатны тусламж шаардлагатай 65 алба хаагчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлснээс 18 алба хаагч орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан. 10 алба хаагч дараагийн лавлагаа шатны эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна. Цэргийн төв эмнэлэгийн явуулын амбулаторийн эрт илрүүлэг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 96 алба хаагч буюу 81.3%-ийг хамруулж, үндсэн болон хавсарсан оношийн улмаас эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналт, нарийвчилсан шинжилгээ, эмчилгээнд 15 алба хаагчийг хамруулаад байна. Онцгой Жаргалант сувилалд байгууллагын алба хаагч, ар гэрийхнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах нөхцөлийн дагуу 3 удаа албан бичгээр хүсэлт хүргүүлж, 41 алба хаагч буюу 34.7%-ийг, 33 ар гэрийн гишүүд, нийт 74 хүнийг архаг, хууч өвчнийг эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээ, сэргээн засах бариа засалд хамруулаад байна.
4.6	ОБЕГ-ын даргын 2014 А/339 тушаал	“Өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах заавар”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд Эрэн хайх, аврах ажиллагааны болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх дадлага, сургалт зохион байгуулах.	Улсын төсвөөс	Сургалтын тоо	3	14	2024 онд Эрэн хайх, аврах салбарын алба хаагчид 18 аж ахуй нэгжид Эрэн хайх, аврах ажиллагааны болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалтыг давхардсан тоогоор 655 ажилтан, алба хаагчийг хамруулан зохион байгуулсан. Тус байгууллагын онцлог, барилгын хийц бүтэц, байршил, тэсэрч, дэлбэрэх аюулын зэрэглэл, усан хангамж, авралтын зам гарц, ажилтан алба хаагчдын судалгаа гаргаж авсан. Мөн Эрэн хайх, аврах салбарын алба хаагчид Гал унтраах аврах 15 дугаар ангитай хамтран “Өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах заавар”-ын хэрэгжилтийн хүрээнд 3-н аж ахуйн нэгжид аврах ажиллагааны тактикийн дадлага сургуулийг зохион байгуулсан. Тус сургалтад аж ахуйн нэгж, байгууллагаас 232 ажилтан алба хаагч, 18 техник, Онцгой байдлын албанаас давхардсан тоогоор 30 алба хаагч, 4 техник хэрэгсэл оролцсон.

4.7	Улсын нөөцийн тухай хууль	144 дүгээр салбарын өвсний хашааг шинэчлэн засварлах ажлын зардлыг шийдвэрлүүлж, бүрэн шинэчлэх	Төсөл хөтөлбөр	Ажлын байрны эмх цэгц, аюулгүй байдал сайжирна.	-	90%	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 144 дүгээр салбарын өвсний хашаа, сарааны засварын ажлын хөрөнгө оруулалтыг тусгуулж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. 144 дүгээр салбарын өвсний хашаа, сарааг шинэчлэн, засварлах ажлыг батлагдсан төсвийн хүрээнд хугацаанд нь гүйцэтгэж, тайланг хүргүүлсэн
4.8	ОББ 2024 оны зорилт-3	Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Хөрөнгө шаардлагагүй	Биелэлтийн хувиар	95%	100%	Онцгой байдлын байгууллагын нэгдсэн тогтолцоонд шилжсэний 20 жилийн ой, байгууллагын дотоод албаны зохион байгуулалт, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд тус газрын зөвлөлүүд 39 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 3454 алба хаагч, ар гэрийг хамруулж төлөвлөгөөний биелэлтийг 95%-тай хангасан. Үүнд: Онцгой байдлын газрын орон тооны бус соёл, урлагийн зөвлөлөөс 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг 90%-тай хангаж салбар, нэгжийн дунд "Урлагийн наадам" зохион байгуулж, шалгарсан 4 номинацийн 12 алба хаагч Зүүн бүсийн Хэнтий, Дорнод аймгийн урлагийн бүрэлдэхүүнтэй хамтарч ОБЕГ-ын хэмжээнд зохион байгуулсан урлагийн наадамд амжилттай оролцож, "ТУСГАЙ БАЙР"-ын шагнал хүртэл ирсэн. Мөн байгууллага сурталчлах ажлын хүрээнд 10 алба хаагч "Иргэн бүрийн оролцоо-Эрсдэлийг давах хүч" уриатай хээрийн түймрийн эрсдэл бүхий 4 суманд сургалт олон нийтийн соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээ, урлагийн хамтарсан тоглолтыг зохион байгуулсан. Орон тооны бус Гэр бүл, залуучуудын зөвлөлөөс төлөвлөгөөний биелэлтийг 95%-тай хангаж 4 нэгдсэн арга хэмжээ, 8 удаагийн сургалтын арга хэмжээ зохион байгуулж, алба хаагч, ар гэрийн 850 орчим хүн хамруулсан. Алба хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 12 алба хаагчдын ар гэрийн гачигдал, хурим, найр, тусламж дэмжлэгт дотоод нөөц боломжийг ашиглан 8.000.000 төгрөг, 17 алба хаагчийг орон байраар, 8 алба хаагчийг төсөл хөтөлбөрт хамруулж нийт 33.600.000 төгрөг зарцуулж ажилласан. Орон тооны бус биеийн тамир, спортын зөвлөлөөс төлөвлөгөөний биелэлтийг 100%-тай хангаж спортын 4,

							бусад 8 арга хэмжээг зохион байгуулж оролцон нийт давхардсан тоогоор 1322 алба хаагч, гэр бүлийн гишүүд, иргэд олон нийтийг хамруулж ажилласан. Орон тооны бус ахлагчийн зөвлөл нь 2024 оныг “ахлагчийн жил” болгон зарласантай холбоотой мэргэжил ур чадварыг хөгжүүлэх сургалт, олон нийтийн арга хэмжээнд түлхүү оролцож гадаадын 3 сургалтад 11, дотоодын 7 сургалтад 18, нийт 29 ахлагч, байгууллага, орон нутаг, улсын чанартай урлаг, спорт, олон нийтийн 12 арга хэмжээнд давхардсан тоогоор 1260 алба хаагч хамрагдсан байна.
4.9	Онцгой байдлын газрын даргын “2024 оны сургуулийн жилд сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай” тушаал	Онцгой байдлын газрын жолооч нарт мэргэжлийн ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах.	Хөрөнгө шаардл агагүй	Сургалтад хамрагдах алба хаагчдын хувь	90%	95%	Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 2/358 дугаар албан бичгийн дагуу Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах үндсэн болон тусгай зориулалтын автомашины жолооч бүрэлдэхүүний 2024 оны 1-3 дугаар улирлын сургалтыг төлөвлөгөөний дагуу 2024 оны 03 дугаар сарын 28, 29, 2024 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр тус тус зохион байгууллаа. Сургалтад Гал түймэр унтраах, аврах 15,47 дугаар ангийн Гал унтраах автомашины жолооч 15, Эрэн хайх, аврах салбарын шуурхай албаны автомашины жолооч 3 нийт 18 алба хаагч танхимаар, Гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн 4, Эрэн хайх аврах бүлгийн 1 алба хаагч цахимаар сургалтад хамрагдсан. Онцгой байдлын газрын даргын тушаалаар ГТУА 15 дугаар ангийн 2 жолоочийг шатны автомашин дээр сургах зорилгоор танхимын болон дадлага сургуулилт хийлгэсэн. Дээрх сургалт зохион байгуулагдсанаар шинэ томилогдсон жолооч нарын мэргэжлийн мэдлэг ур чадвар зохих хэмжээгээр дээшилж байна.
4.10	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/397 тоот тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын	Алба хаагчдын сэтгэл зүй, бие бялдрын түвшинг дээшлүүлнэ.	Дотоод нөөц бололц оо	Норматив хангасан алба хаагчдын хувь	85%	88%	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/397 тоот тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн нормативыг хангуулах ажлын хүрээнд салбар, нэгжүүд сар бүр бие бялдрын сорил, шүүлэг авч, үр дүнг тооцож ажилласан. Тус газрын орон тооны бус биеийн тамир, спортын зөвлөлөөс 2024 онд алба хаагчдын биеийн тамирын бэлтгэлжилтийн нормативыг батлагдсан удирдамж, зааврын дагуу хагас бүтэн жилээр авахад нийт хамрагдвал зохих 108

	алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн норматив"						алба хаагчаас 103 буюу 95.3% хамрагдсан. Бие бялдарын үзүүлэлтийг өмнөх оны мөн үеийн үнэлгээний дүнтэй харьцуулбал онц-55 буюу 36%-аар өссөн, сайн-35, дунд-13 буюу 27.7%-аар буурсан, муу-0 үнэлгээтэй амжилт 2.8%-иар өсөж 88.7% "Сайн" гэсэн үнэлгээг хангасан үзүүлэлттэй байна.
4.11	ОББ 2024 оны зорилт-3	Онцгой байдлын байгууллагын нэгдсэн тогтолцоонд шилжсэний 20 жилийн ойн хүрээнд Онцгой байдлын газрын салбар нэгжийн дунд "Урлаг, спортын наадам" зохион байгуулах.	Дотоод нөөц боломж	Урлаг, спортын наадмын тоо	1	2	Онцгой байдлын байгууллагын нэгдсэн тогтолцоонд шилжсэний 20 жилийн ойн хүрээнд Онцгой байдлын газрын соёл, урлагийн зөвлөлөөс салбар, нэгжийн дунд "Урлагийн наадам" зохион байгуулж, шалгарсан 4 номинацийн 12 алба хаагч Зүүн бүсийн Хэнтий, Дорнод аймгийн урлагийн бүрэлдэхүүнтэй хамтарч ОБЕГ-ын хэмжээнд зохион байгуулсан урлагийн наадамд амжилттай оролцож, "ТУСГАЙ БАЙР"-ын шагнал хүртсэн. Мөн байгууллага сурталчлах ажлын хүрээнд "Иргэн бүрийн оролцоо-Эрсдэлийг давах хүч" уриатай хээрийн түймрийн эрсдэл бүхий 4 суманд сургалт олон нийтийн соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээ, урлагийн хамтарсан тоглолтыг зохион байгуулсан. Тус газрын биеийн тамир, спортын зөвлөлөөс спортын 3 төрөлтийн нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, алба хаагчид, гэр бүл, ахмадын хамруулсан 160 орчим хүн оролцож шилдгүүдээ шалгаруулж, шагнаж урамшуулсан.
4.12	Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоол	Алба хаагчдаар "Угийн бичиг" хөтлүүлэх, мэргэжлийн байгууллагаас сургалт авах	Үйл ажиллагааны зардал	Угийн бичиг хөтлөх алба хаагчдын хувь	20%	30%	Онцгой байдлын газраас "Гэр бүлийн уулзалт, зөвлөгөөн-2024" нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран 45 алба хаагч, түүний гэр бүлийнхэнд "Ургийн мод" сэдэвт ургийн бичиг хөтлөх сургалт, мэдээлэлд хамрагдаж, алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлсэн. Мөн Түмэнцогт сумын Соёлын төвөөс зохион байгуулсан "УДМАА МЭДЭЖ-УРГАА МӨНХЛӨЕ" угийн бичгийн сургалтад 12 хамрагдсан. Сургалтаар угийн бичиг бичих заавар, гарын авлага, "Овгийн шастир" номыг алба хаагчдад тарааж өгсөн.

4.13	Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоол	Алба хаагчдад үндэсний бичгийн чадавхыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Дотоод нөөц боломж	Үндэсний бичгийн мэдлэгтэй болсон алба хаагчдын хувь	30%	40%	2024 оны эхний хагас жилийн хичээлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу алба хаагчдыг Лаборатори 1 дүгээр бүрэн дунд сургуультай хамтран ажиллаж Үндэсний бичгийн 7 удаагийн 14 цагийн хичээл сургалтад хамруулсан. Мөн Улсын хэмжээнд зохион байгуулсан түвшин тогтоох шалгалт болон 1 ЕБС-иас авсан түвшин тогтоох шалгалтад нийт бие бүрэлдэхүүнийг хамруулж ажилласан.
------	---	---	--------------------------	---	-----	-----	--

СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР